

ХШУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2016 оны 9-р сарын 12-ны хурлаар батлав.

Эрдмийн зөвлөлийн дарга:  Н.Баатарбилэг/



ХШУИС-Д ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 МУИС-ийн ХШУИС-д эрдэм шинжилгээний семинар (цаашид “ЭШС” гэнэ) төлөвлөх, үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм журамд нийцүүлэн зохион байгуулах, хяналт тавих, үнэлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2 ХШУИС-д ЭШС зохион байгуулах журмыг ХШУИС-ийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж, захирлын тушаалаар баталж мөрдөнө.

1.3 ЭШС-ын үйл ажиллагаа нь хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн чиглэлээрх судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэм шинжилгээний ажлын онол практикийн түвшин, чанар, үр дүнг дээшлүүлэх; залуу багш нар, докторантуудад судалгааны арга барил эзэмшүүлэх, тэдний судалгааны ажлыг удирдан чиглүүлэх; багш судлаачдын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд чиглэгдэнэ.

1.4 Дараах ЭШС-уудыг зохион байгуулна. Үүнд:

- 1) ХШУИС-ийн Эрдмийн зөвлөлийн хүндэтгэлийн семинар;
- 2) ХШУИС-ийн их семинар;
- 3) Тэнхимийн семинар;
- 4) Судалгааны багийн семинар;
- 5) Сургалтын багийн семинар;
- 6) Бусад семинар.

Хоёр. Эрдэм шинжилгээний семинар зохион байгуулах

2.1 ХШУИС-ийн Эрдмийн зөвлөлийн хүндэтгэлийн семинар


2.1.1 ХШУИС-ийн Эрдмийн зөвлөлийн дарга семинарыг удирдана. Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга семинарын бэлтгэл ажлыг хариуцан ажиллана.

2.1.2 ХШУИС-ийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр “Хүндэт доктор”, “Хүндэт профессор” цол олгох, хүндтэй зочдод өргөмжлөл гардуулах зэрэг ёслолын үйл ажиллагааг тохиолдуулан зохион байгуулна.

2.1.3 ХШУИС-аас тэтгэвэр тогтоолгож байгаа профессоруудын хүсэлтээр уг семинарт илтгүүлж, хүндэтгэл үзүүлж болно. Энэ тохиолдолд семинарыг илтгэгчийн тэтгэвэр

тогтоолгох хичээлийн жилд багтааж зохион байгуулна.

2.1.4 Семинарт илтгэгчид мөнгөн урамшуулал олгох ба урамшууллын хэмжээг тухайн жилийн төсөвт суулгаж, батлуулсан байна.



2.2 ХШУИС-ийн их семинар

2.2.1 Эрдэм шинжилгээ хариуцсан дэд захирал семинарыг удирдана. Их семинарын төлөвлөгөөг хагас жилээр гаргаж үр дүнг жилийн эцэст тайлагнана.

2.2.2 ХШУИС-ийн их семинарыг гадаад дотоодын нэр хүндтэй эрдэмтдийг урьж илтгүүлэх, шинээр докторын зэрэг хамгаалсан эрдэмтдийн ажлын үр дүнг сонсох зэрэг тохиолдолд зохион байгуулна.

2.2.3 Зөвхөн уригдсан илтгэгчид мөнгөн урамшуулал олгох ба урамшууллын хэмжээг тухайн жилийн төсөвт суулгаж, батлуулсан байна.

2.3 Тэнхимийн семинар

2.3.1 Тухайн тэнхимийн эрхлэгч семинарыг хариуцан зохион байгуулж хяналт тавина. Тэнхимийн семинарыг бусад тэнхимтэй хамтарсан эсвэл өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулж болно.

2.3.2 Семинарыг жил бүрийн 9 дүгээр сарын 3 дахь 7 хоногоос эхлэн долоо хоногийн тодорхой гарагт зохион байгуулахаар улирал бүрийн эхэнд төлөвлөсөн байна.

2.3.3 Семинарт тухайн тэнхимийн бүх багш, докторант, магистрант оюутнууд оролцох бөгөөд тухайн хичээлийн жилд тэнхимийн багш бүр нэгээс доошгүй удаа илтгэсэн байхаар зохион байгуулна.

2.3.4 Илтгэгч өөрийн судалгааны ажлын сүүлийн үеийн ололт амжилт, хийх судалгааны ажлаар шийдвэрлэх асуудлаа хэлэлцүүлнэ. Түүнчлэн өөрийн судалгааны чиглэлтэй шууд холбоотой, (гадаад хэл дээр хэвлэгдсэн) сүүлийн үеийн онцгой сайн үр дүнтэй ажил, тойм өгүүллийн агуулгаар илтгэж болно.

2.3.5 Танхимын сургалтаа дуусгасан магистрант оюутан урьдчилсан хамгаалалтын өмнөх илтгэл байдлаар судалгааны асуудал, судалж мэдсэн байдал, гаргасан үр дүн, дүгнэлтээ хэлэлцүүлж, үнэлүүлнэ.

2.3.6 Докторант оюутан суралцсан эхний жилийнхээ төгсгөлд судалгааны асуудлын тойм (тухайн судалгааны асуудлаар олон улс, бүс нутаг, Монгол Улсын хэмжээнд хийгдсэн ажлууд, сэдвийн судлагдсан байдлын талаар тойм илтгэл тавина. Энэ нь судалгааны чиглэлийг танилцуулах зорилготой бус, өөрийн судалгааны ажил, судалгаагаар шийдвэрлэх асуудал, эсвэл шинээр боловсруулах арга зүй, шинэлэг тал, тухайн асуудлыг шинжлэх ухааны аргаар шийдэх боломжтой эсэх, асуудлыг шийдсэнээр олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлэгдэх боломжтой эсэх зэрэг асуудлыг оролцуулан)-ыг илтгэж судалгааны ажлын үр дүнгээр хамгаалах шинэлэг асуудлаа тодруулж, дүгнэлт гаргуулна. Хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд удирдагчийн

саналыг харгалзан сэдэв, удирдагчийг солих, докторантаас хасах санал оруулж болно.

2.3.7 Танхимын сургалтаа гүйцээж, хамгаалалтын шаардлага хангасан докторант судалгааны ажлын үр дүнгээ нэгтгэн тэнхимийн өргөтгөсөн семинараар тухайн сэдэвт ажлыг “урьдчилсан хамгаалалтад оруулах тухай” гэсэн асуудал болгон хэлэлцүүлж, урьдчилсан хамгаалалтад оруулах эсэх талаар дүгнэлт, тодорхойлолт гаргуулна.

2.3.8 Докторантын диссертацийн урьдчилсан хамгаалалтыг МУИС-ийн захиралын 2016 оны 5-р сарын 4-ний өдрийн А/112 дугаар тушаалаар батлагдсан түр журмын дагуу тэнхимийн өргөтгөсөн семинараар хэлэлцэнэ. Энэ семинарт тэнхимийн докторын зэрэгтэй гишүүдийн 75-аас доошгүй хувийг оролцуулсан байх ба мэргэжлийн тэнхимийн багш нар, мэргэжлийн чиглэлийн бусад сургууль, судалгааны багийн судлаачид, хамгаалуулах зөвлөлийн гишүүдийг оролцуулж өргөтгөнө. Хамгаалуулах зөвлөлийн уригдсан гишүүд санал өгөх эрхтэй оролцоно.

2.4 Судалгааны багийн семинар

2.4.1 Судалгааны багийн семинар нь залуу судлаачдын хувьд өөрийн ажлаа танилцуулах, илтгэх, асуух, хариулах, шүүн хэлэлцэх, шинжлэх ухааны бичлэгийн чадвараа сайжруулах зэрэг эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд суралцах үндсэн орчин байна.

2.4.2 Семинарыг судалгааны багийн ахлагч профессор, дэд профессор зохион байгуулж, хяналт тавина. Судалгааны багууд семинараа хамтран зохион байгуулж болно.

2.4.3 ХШУИС-ийн багш, докторант, магистрант оюутан судалгааны 1-ээс доошгүй багийн семинарт хамрагдсан байна. Судалгааны багт бакалаврын түвшний оюутнууд, гадны судлаач, оюутан, багш нарыг оролцуулж болно.

2.4.4 Судалгааны багийн гишүүд хагас жилд дор хаяж 1 удаа өөрийн судалгааны ажлын үр дүн, явцын талаар эсвэл олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлд хэвлэгдсэн ижил төстэй судалгааны өгүүллийг танилцуулж илтгэнэ.


2.4.5 Семинарын ахлагч жилд 1-ээс доошгүй удаа бусад судалгааны багийн семинарт сууж, туршлага судална.

2.5 Сургалтын багийн семинар

2.5.1 ХШУИС-ийн хөтөлбөрийн дэд хороо эсвэл Тэнхимийн хөтөлбөрийн дэд хорооны өгсөн чиглэлийн дагуу сургалтын хөтөлбөр, хөтөлбөрт тусгагдсан бүлэг хичээл, нэг хичээлийн агуулгыг сайжруулах, олон багш нэг хичээлийг заадаг бол агуулгыг зохистой уялдуулах, үнэлгээг жигд байлгах зорилгоор зохион байгуулна.

2.5.2 Хөтөлбөрийн дэд хорооноос томилогдсон багийн ахлагч семинарыг удирдаж, зохион байгуулна.

2.5.3 ХШУИС-ийн профессор, багш нар 1-ээс доошгүй сургалтын багийн семинарт хамрагдсан байна.



2.6 Бусад семинар

2.6.1 Сайн дурын үндсэн дээр зохион байгуулсан ЭШС-ийг бусад семинар гэж тооцно.

2.6.2 Семинарын дотоод дэгийг семинар зохион байгуулагч гаргаж, хэрэгжүүлнэ.

Гурав. ЭШС-ийн зохион байгуулалтад хяналт тавих, тайлагнах

3.1 ЭШС зохион байгуулагч (тэнхим, судалгааны баг, багш) семинарийн хуваарийг харгалзах нэгжээр хэлэлцүүлж, батлуулна.

3.2 ЭШС зохион байгуулагч семинарын тэмдэглэл хөтөлж, тайлан гаргана.

3.3 Сургалтын алба батлагдсан хуваарийн дагуу ЭШС зохион байгуулах анги танхимын зохицуулалтыг хийнэ.

3.4 Энэ журмын дагуу батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулагдсан ЭШС-т оролцсон багшид журамд зааснаар кредит цагийг тооцно. Албан бус бусад семинарыг "Б" цагт тооцохгүй харин "В" цагт тооцуулж болно.

--- о О о ---